

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2015 оны 08 сарын мэдээ

2015.08.28

Аялал жуулчлал

Хархорин сумын Орхон голын хөвөөнд аялагч жуулчидад зориулан 2 отоглох цэгийг хийж ашиглалтанд орууллаа.



Хятрууны рашаанаас доош 1км зайд амрагчдад зориулсан отоглох цэгийг барьж ашиглалтанд оруулсан.



Батөлзий сумын Могойт хайрхан нөхөрлөлтэй байгаль хамгаалал, аялал жуулчлалын хамтын менежментийн үндсэн дээр аялагчдад мэдээлэл өгөх нэвтрэх цэгийн байр, бие засах газрыг барьж ашиглалтанд оруулсан.



Мэдээлэл сурталчилгаа

Орхоны хөндийн БЦГ-т байгаль хамгаалан, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг бүлэг нөхөрлөлүүд энэ сарын 14-17 өдрүүдэд Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлалын үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа. НҮБ-ын ТХГНСБэхжүүлэх нь төслийн санжүүжилтээр хийгдсэн туршлага судлах аялалд Батөлзий сумын аялал жуулчлалын Хүрмэн чулуу нөхөрлөл, Хужирт сумын Сайхан булаг нөхөрлөл, Хархорин сумын Их Эрээн, Дулаан хайрхан нөхөрлөлүүдийн гишүүд төлөөлөгчид оролцсон юм.





НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн ТХГНСБ нь төслийн санхүүжилтээр хийгдэж буй цогцолборт газрын баримтат кино хийх зураг авалтын багтай хамтран Уянга, Бат-Өлзий, Хашаат, Хотонт, сумдын байгаль, түүх, соёлын дурсгалт газруудыг танилцуулан киноны зураг авалтыг хийж гүйцэтгэлээ.

Судалгаа шинжилгээ

Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өвөрхангай аймгийн Хархорин Хужирт сумдын ТХГН болон түүний орчны бүс дэх Бэлчээрийн нөөц даацын үнэлгээний ажлыг доктор Ц.Алтанзул багш болон тус бүс нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлүүдтэй хамтран хийж гүйцэтгэлээ.



Монгол улсын түүх археологийн хүрээлэнгийн Хүннү эртний түүхийн тэнхимийн археологийн хайгуул, малтлага судалгааны багтай 2015 оны 08 сарын 21 өдрөөс цогцолборт газрын Майхан толгой, Ар буланд судалгаа хийх гэрээ байгуулан газрыг хүлээлгэн өглөө.



Байгаль хамгаалал

Хархорин сумын Орхон голын эрэг орчмын хог цэвэрлэгээг Орхон багийн захиргаа, иргэд, Хархорин сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазуудтай хамтран хийж гүйцэтгэлээ.



Хяналт шалгалт

Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу Хархорин сумын Баянзүрх, Бэлчир, Урт, Их нарийн, Сөрт, Шивэрт, Бага нарийн зэрэг газруудаар Ойн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хуулийн хэрэгжилт, ойн дагалт баялаг ашиглах хугацаа, зүй зохистой ашиглалт, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж анхааруулгыг ард иргэдэд ухуулан сурталчилж, санамж тарааж ажиллаа.

Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэх хяналтаар зөрчил гарган хууль тогтоомж зөрчсөн 2 иргэнд захиргааны арга хэмжээ авч экологид учруулсан 1.584.000 төгрөгийг улсын орлого болголоо.

Мэдээ нэгтгэсэн :Мэргэжилтэн

Ч.Суурьтогтох.